



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН,
НОГООН ХӨГЖЛИЙН САЙДЫН
ТУШААЛ

2014 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А-215

Улаанбаатар хот

Төслүүдийн удирдах зөвлөлийг
шинэчлэн томилох тухай

Монгол Улсын Засгийн газрын шугамаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн газартай хамтран хэрэгжүүлж буй төслүүдийн Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулж, төслүүдийн хэрэгжилтийн үр ашигтай байдлыг дээшлүүлэхтэй холбогдуулан "Монгол Улсын Засгийн газрын тухай" хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4, 2 дахь хэсэг, "Гадаадын зээл тусламжийг зохицуулах тухай" хуулийн 14.1.3 дахь заалт, Сангийн сайдын 2011 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжих төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журам"-ын 6.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нэгдсэн Үндэстний Байгууллагын шугамаар хэрэгжүүлж буй "Экосистемд түшиглэсэн дасан зохицох арга хэмжээг уур амьсгалын өөрчлөлтөд өндөр эрсдэлтэй голуудын сав газарт хэрэгжүүлэх нь", "Байгаль нуурын сав газрын хил дамнасан экосистемийн усны нөөцийн нэгдсэн менежмент", "Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг бэхжүүлэх нь", "Монгол орны байгалийн нөөцийн менежменттэй газар нутгийн сүлжээ" төслүүдийн Удирдах зөвлөлийн даргаар Байгаль орчин, ногоон хөгжлийн дэд сайд Б.Тулгыг томилсугай.

2."Экосистемд түшиглэсэн дасан зохицох арга хэмжээг уур амьсгалын өөрчлөлтөд өндөр эрсдэлтэй голуудын сав газарт хэрэгжүүлэх нь" төслийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралт ёсоор;

3. "Байгаль нуурын сав газрын хил дамнасан экосистемийн усны нөөцийн нэгдсэн менежмент" төслийн удирдах зөвлөлийн монголын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралт ёсоор;

4. "Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг бэхжүүлэх нь", "Монгол орны байгалийн нөөцийн менежменттэй газар нутгийн сүлжээ" төслүүдийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг гуравдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

5. Эдгээр төслүүдийн үйл ажиллагааны явц, хэрэгжилтэд хяналт тавьж, зөвлөмж удирдлагаар хангаж ажиллахыг дэд сайд Б.Тулгад үүрэг болгосугай.

6. Энэ тушаал гарсантай холбогдуулан Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын "Төслийн удирдах зөвлөлийг шинэчлэн томилох тухай" 2012 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн А-66 тоот тушаал, "Үндэсний захирал, удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн томилох тухай" 2012 оны 10 дугаар сарын 10-ны Б-16 тоот тушаалын 1, 3, 4 дэх заалт болон 1 дүгээр хавсралт, "Төслийн удирдах зөвлөлийг шинэчлэн батлах тухай" 2013 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А-304 тоот тушаалуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



С.ОЮУН

Байгаль орчин, ногоон хөгжлийн
сайдын 2014 оны 16 дугаар сарын 29-ний
өдрийн АТБ тоот тушаалын 2 дугаар хавсралт



**“Байгаль нуурын сав газрын хил дамнансан экосистемийн
усны нөөцийн нэгдсэн менежмент” төслийн удирдах зөвлөлийн
монголын хэсгийн бүрэлдэхүүн**

| | |
|--------------------------|--|
| Удирдах зөвлөлийн дарга: | Байгаль орчин, ногоон хөгжлийн дэд сайд |
| Гишүүд: | Ус цаг уур, орчны хүрээлэнгийн ус судлалын секторын эрхлэгч Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын хилийн усны асуудал хариуцсан мэргэжилтэн Сэлэнгэ аймгийн Байгаль орчны газрын усны мэргэжилтэн НҮБХХ-ийн Байгаль орчны нэгжийн ахлагч Уул уурхайн яамны Уул уурхайн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн |